



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/158

Мандалговь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "г" дэх заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Сумын 9 дүгээр багийн нутаг дэвсгэр "Их тойруу 9-906" тоотод байршилтай Жангаагийн Соёл-Эрдэнэ (3380072618)-ийн худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалттай 8000 м.кв (0.8 га) газрыг Ганцогтын Мөнхбаясгалан (ЗИ91022216)-д зориулалтын дагуу шилжүүлэн 11 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигчийн газрын гэрчилгээг шинэчлэн олгож, газар эзэмших гэрээ байгуулж ажиллахыг газрын даамал (Л.Хулан)-д зөвшөөрсүгэй.

3. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигч иргэнд үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/244 дүгээр захирамжийн холбогдох хэсэг мөн газар эзэмших эрхийн 000116629 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ